



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/06

Баянсайр

Сумын Засаг даргын зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, сумын Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, бодлого чиглэлийг тодорхойлох, тулгамдсан асуудлыг олон талаас хэлэлцэн оновчтой шийдвэр гаргах, урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсны улмаас тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхэд хэлэлцэн шийдвэр гаргах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Засаг даргын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга: С.Энхтөр –Сумын Засаг дарга

Гишүүд: Б.Бямбаням – Засаг даргын орлогч

Б.Наранбаатар- Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Гэрэлмөнх – Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч, Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн/

О.Дашдаваа –Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Ж. Ганбат – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ц.Дэмчиг –Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ж.Гунгаарэгзэн –ХААН банкны салбарын эрхлэгч

Нарийн бичгийн

Дарга: С.Өлзий-Орших – Хууль эрх зүйн мэргэжилтэн

642101263

2. Сумын Засаг даргын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Зөвлөлийн гишүүдийг ажиллах нөхцлөөр хангаж, хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Наранбаатар), зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Өлзий-Орших)-нэрт даалгасугай.

ДАРГА



С.ЭНХТӨР

Засаг даргын 2022 оны 01 дүгээр
сарын 28 ны өдрийн 416 дугаар
захирамжийн хавсралт

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ БОЛОН АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ ЖУРАМ**

Нэг. Журмын зорилго:

1.1. Сумын Засаг даргад бодлогын зөвлөгөө өгөх, хэлэлцэх асуудлыг хуулийн хүрээнд оновчтой тодорхойлж, Засаг даргаас гарсан шийдвэрийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл:

2.1. Сумын Засаг даргын зөвлөл нь сум, орны ажил амьдралд тохиолдсон аливаа асуудлыг тухайн нөхцөл байдалтай зохицуулан хууль дүрэм, журмын дагуу асуудалд хандан туслах үүрэгтэй.

2.2. Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг дарга, тухайн шатны ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд ажиллана.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааг Засаг дарга удирдах бөгөөд эзгүйд Засаг даргын орлогч хурлыг удирдана.

2.4. Зөвлөлийн гишүүд эрхэлсэн ажил, аль нэг салбарын явцуу бодлогыг үл харгалзан асуудалд улс, аймаг, сумын нийтлэг эрх ашгийн үүднээс хандана.

2.5. Зөвлөлийн гишүүдээс тавьсан саналыг Засаг даргын шийдвэрт тусгуулахаар тэмдэглэл хөтөлнө.

Гурав. Зөвлөл дараах асуудлыг хэлэлцэнэ.

3.1. Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарах асуудлыг хэлэлцэх

3.2. Харьяа газруудын ерөнхий менежер болон сумын Засаг даргын Тамгын газрын ажлын тайлан, шагнал урамшууллын асуудлыг хэлэлцэх

3.3. Засаг даргын гаргасан шийдвэрийн биелэлт, ажлын төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилт

3.4. Засаг даргын Тамгын газар, баг, төсөвт байгууллагуудын ажлын хариуцлага, зохион байгуулалт, үр дүн шийдвэр гаргахад шаардлагатай цаг үеийн бусад асуудлыг хэлэлцэнэ.

Дөрөв. Зөвлөлийн хуралдаан:

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна.

4.2. Зөвлөлийн хуралдааныг гишүүдийн 50 хувиас дээш нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

4.3. Зөвлөлийн хуралдаанд асуудал оруулж байгаа болон бусад холбогдох хүмүүсийг оролцуулан өргөтгөн хийнэ.

4.4. Хуралдааныг сард нэг удаа сар бүрийн эхний 7 хоногийн Мягмар гараг бүр тогтмолжуулан хуралдах бөгөөд Засаг даргын санаачлагаар шаардлагатай үед зарлан хуралдуулна.

Тав. Хуралдаанд асуудал боловсруулж оруулах:

5.1. Зарим шаардлагатай үед асуудал шийдвэрлэх үүднээс зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэнэ.

5.2. Хуралдаанд асуудал оруулах ажилтан уг асуудлаар гаргах шийдвэрийн төслийг боловсруулж төслөө Засаг даргад танилцуулж хуралдаанд оруулах зөвшөөрөл авсан байна.

5.3. Хуралдаанд оруулах асуудал, гаргах шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэл тогтоол шийдвэрийн давхардал, хүчингүй болсон заалт байгаа эсэхийг сайтар хянана.

5.4. Хуралдаанд хэлэлцэхээр асуудлыг оруулж байгаа мэргэжилтэн тухайн хэлэлцэх асуудлыг хурал болохоос нэг хоногийн өмнө Засаг даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулж Тамгын газрын даргад өгсөн байна.

5.5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хэлэлцэх асуудлыг болон тараах материалыг зөвлөлийн гишүүдэд нэг хоногийн өмнө тарааж хурлын зарыг хүргэнэ.

5.6. Хуралдааны тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, гарсан санал бодитой байдал, олонхи гишүүдийн саналаар шийдвэрлэсэн асуудал, шийдвэрийг тодруулан бичиж шивж, баталгаажуулан ажлыг 3 хоногийн дотор зөвлөлийн даргаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

5.7. Гарсан шийдвэрийг ажлын 3 хоногийн дотор холбогдох хүмүүс байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Бусад асуудал:

6.1. Засаг даргын зөвлөлөөс гарсан шийдвэрийг зохион байгуулж, хэрэгжүүлэх, биелэлтэнд нь хяналт тавих ажлыг Тамгын газрын дарга, зөвлөлийн гишүүд хариуцана.

6.2. Зөвлөлөөс ажиллах журамд орох өөрчлөлтийг хуралдаанаар шийдвэрлэнэ.

_____ оОо _____